

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД  
ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 6 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Х.Тэмүүжин**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хууль болон дагалдах бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг нэгдсэн хуралдаанаар 2015 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2015 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг хуулийг хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдсэн эсэхэд болгоомжтой хандах, Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Р.Гончигдорж нар хуулийн төсөлд нэр томъёог хэрэглэхдээ бусад хууль тогтоомжтой уялдуулах, ямар утга, агуулгаар хэрэглэж байгааг маш нарийн тодорхойлох, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Х.Тэмүүжин нар хуулийн хэрэгжилтийг хангахад Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарлаа хандуулж, хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд хуулийг олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх, бэлтгэлийг хангахтай холбогдуулан шилжилтийн үеийн зохицуулалтыг хангах талаар дагаж мөрдөх журмын хууль болон, хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолын төслийг боловсруулан батлах нь зүйтэй гэж үзсэн болно. Түүнчлэн хуулиудын уялдааг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, тогтоолын төслийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог хангах, төрийн үйл ажиллагаа хүнд сурталгүй, үр дүнтэй, үр ашигтай байх, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэсэн үзэл баримтлалын хүрээнд энэ хуулийн хэрэгжилтэд Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарах, хяналт тавих, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болох хугацааг бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд бүрэн эхээр нь нийтлүүлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэхээр заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 7-д "Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж нь тэдгээрт болон хуульд өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно" гэсэнтэй зөрчилдөж байгааг Хууль зүйн байнгын хороо хэлэлцүүлгийн шатанд анхаарах зэрэг саналуудыг тус тус гаргаж байсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо дээрх хуулийн төслүүдийг хэлэлцээд тус Байнгын хорооны хуралдаан дээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй 8 саналыг Та бүхэнд хүргүүлж байна.

Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдээ, Захиргааны ерөнхий хууль болон дагалдах бусад хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**А.БАКЕЙ**

## **ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг доор дурдснаар өөрчлөн найруулах:**

5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг доор дурдсан нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:

5.1.1.төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;

5.1.2.хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;

5.1.3.захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд;

5.1.4.үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, холбоо, харилцаа, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;

5.1.5.нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд**

**2.Төслийн 5.4-т заасан “Монгол Улсын Их Хурал,” гэснийг “Монгол Улсын Их Хурлаас гарсан шийдвэр” гэж өөрчлөх.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Х.Тэмүүжин**

**3.Төслийн 28.1.1 дэх заалтын “сонсох ажиллагааг хийх боломжгүй, эсхүл” гэснийг хасах.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин**

**4.Хуулийн төслийг 32.3, 73.2 дахь заалтыг тус тус хасах.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Х.Тэмүүжин**

**5.Хуулийн төслийн 42.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:**

“42.2.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хуульд заасан шаардлагад үндэслэн, зорилгодоо нийцүүлэн сонгох боломжийг хэрэглэнэ.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин**

**6.Төслийн 60.1.2-ыг “60.1.2.тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх” гэж өөрчлөх.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Х.Тэмүүжин**

7.Төслийн 64.2 дахь хэсгийг “64.2.Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлнэ.” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин**

8.7 дахь санал батлагдсантай холбогдуулан төслийн 64.3-т заасан “Засгийн газраас баталснаас (Засгийн газрын тогтоол) бусад” гэснийг тус тус хасах, үүнтэй нийцүүлэн 66.3.4, 66.7, 67.1, 68.2 -т заасан “ Улсын Их Хурлын Тамгын газрын хууль зүйн асуудал хариуцсан нэгж” гэснийг хасах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин**